

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал .....	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	19
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	22
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	23

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН  
ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН  
ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ОЧИРБАТ ТАНАА

2020.02.20 № 06/545  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Аудитын гол асуудал


Тус коллеж нь кассаар бэлэн авсан 72,738.9 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэхгүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 35.3, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дугаар заалтыг тус тус зөрчиж, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Үүрэг, хариуцлага

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Очирбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цаашид мөнгөн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, үргүй зардал гаргахгүй байх, төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журам зааврыг мөрдөж ажиллах, бүртгэл тайлагналыг сайжруулах, байгууллагын дотоод хяналтын системийг сайжруулах талаар Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 10 дугаар сарын 30-наас 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын захиалгаар “Баянсуварга Аудит.” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/007 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Өндөр шаардлага бүхий ажлын байрны эрэлтэд нийцсэн мэргэжлийн өндөр ур чадвар, дадал, зөв төлөвшилтэй мэргэжилтэн бэлтгэхэд" оршино.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн үйл ажиллагааны чиглэл нь мэргэжил эзэмшүүлэх, техникийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулах гэж тодорхойлжээ.

### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллеж нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 16 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 2,740,207.9 мянган төгрөгөөс тооцон 27,402.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар тооцон 36,264.1 мянган төгрөгөөр тогтоов. Гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны суурь үзүүлэлтийн дүнгээс материаллаг байдлын түвшнийг тооцсон тул мөнгөн дүнгийн хувьд өөрчлөлт орсон болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 616,888.0 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага		93,907.5	93,907.5
Урьдчилгаа	-	-	
Бараа материал	307,280.4	352,627.5	45,347.1
Үндсэн хөрөнгө	8,228,778.6	7,472,636.0	(756,142.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>8,536,059.0</b>	<b>7,919,171.0</b>	<b>(616,888.0)</b>
Өр төлбөр	9,837.4	-	(9,837.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>8,536,059.0</b>	<b>7,919,171.0</b>	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>8,536,059.0</b>	<b>7,919,171.0</b>	<b>(616,888.0)</b>

Авлага дансны үлдэгдэл нийт 93,907.5 мянган төгрөгөөр өссөн нь 2019-2020 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийн төлөгдөөгүй үлдэгдлийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 45,374.1 мянган төгрөгөөр өссөн нь хичээл үйлдвэрлэлийн дадлагын материал төсвийн хөрөнгөөр худалдан авснаас зарцуулагдаагүй үлдэгдэл 21,957.3, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яамнаас хуваарилагдан ирсэн 23,413.7 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийн дагалдах хэрэгсэл бүртгэн тайлагнаснаас шалтгаалсан байна. Бараа материалын дансны үлдэгдэлд эд хариуцагчид хариуцуулсан эргэлтийн хөрөнгө байгааг 2019 оны жилийн эцсийн тооллогоор тоолж, өмч хамгаалах комиссын хурлаар хэлэлцүүлэн акталж холбогдох байгууллагад данс бүртгэлээс хасах зөвшөөрөл авахаар шийдвэрлэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь 374,274.9 мянган төгрөгийн үнэ бүхий газрыг шилжүүлж данснаас хассан, тайлант оны элэгдлийн зардал зэргээс шалтгаалжээ. Хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 120,814,5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.



Өр төлбөр дансны үлдэгдэл 9,837.4 мянган төгрөгөөр буурсан нь 2018 оны жилийн эцсийн ХАОАТ-ын өглөг барагдуулснаас шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 2,595,641.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,350,641.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 245,000.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын төсвөөс 2,350,614.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгожээ. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 245,000.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 250,756.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 756.3 мянган төгрөг буюу 2.3 хувиар давж биелсэн суралцагсдын тоо нэмэгдэж орлого нэмэгдсэн, дотуур байрыг үнэ төлбөргүй болгосноос туслах үйл ажиллагааны орлого буурсан зэргээс шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,578,663.3 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан авч үзвэл:

- Байр ашиглалттай холбоотой зардал 12,273.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь цэвэр бохир ус, халаалтын зардлуудын гүйлгээг бүлгийн дүнгээр гүйлгэж тайлагнасан.
- Бага үнэтэй түргэн элэгдэх зардал төсвөөс 5,041.2 мянган төгрөгөөр хэтэрсэн нь байгууллагын цэвэрлэгээ, аж ахуйн хэрэгцээний зардлын төсөв 1,514.7 мянган төгрөг батлагдсан, үнийн өсөлт зэргээс шалтгаалан хэтэрсэн боловч хангамж, бараа материалын зардал бүлгийн дүнгээр хэтрээгүй болно.
- Даатгалын үйлчилгээний зардал 1,980.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь 2019 онд суралцагчдын гэнэтийн ослын даатгал гэрээ хийж төлөгдөөгүй.
- Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал зардал 5,608.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсан 1 багш таван жилд олгогддог тэтгэмжийн зардлаа авахаас өмнө ажлаасаа чөлөөлөгдсөнтэй холбоотой байна.

Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 27,491.2 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий 85,543.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, бараа үйлчилгээний зардалд 55,603.0 мянган төгрөг зарцуулж, тэтгэмж урамшууллын зардалд 29,940.2 мянган төгрөгийг зарцуулж, 0.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 16 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүлжээ.



Аудитаар нийт 95,020.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 10,320.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 72,738.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 11,961.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнд:

1.Тус коллежийн мөнгөн хөрөнгийн зардалтай холбоотой 3,138.0 мянган төгрөг, балансын данстай холаоотой 7,182.0 мянган төгрөгийг залруулсан.

2.Тус коллеж нь кассаар бэлэн авсан оюутны сургалтын төлбөр, элсэлт, бүртгэлийн хураамж болон бусад орлого зэрэг 72,738.9 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэхгүйгээр ном хэвлэл худалдан авах, биеийн тамир, уралдаан тэмцээний зардал болон урсгал засварын зардалд зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-“Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна”, 35.3-т “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банкинд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ”, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кастаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг (түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй) ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар илэрсэн 11,961.7 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Хичээл үйлдвэрлэлийн дадлагын материалыг худалдан авахад хуулийн дагуу тендер зарласан эсэх, хичээл үйлдвэрлэлийн дадлагын ажилд олгосон бараа материалын зарцуулалт, үр дүнг тооцож, дадлагын хичээлийн үр дүнд бий болгосон бүтээгдэхүүнийг орлогод авч нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд тусгасан талаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 4 төрлийн 151 мэдээллээс 143 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 36,478.1 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй 84,700.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тооцсон 36,264.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшингээс их байгаа тул хязгаарлалттай дүгнэлтийг өгч байна.

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Авлагын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Цалингийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж, дансны өр төлбөрийн тооцоог хянаагүйгээс жилийн эцсийн санхүүгийн тайланд ХХОАТ, НДШ-ийн 2,516.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай нийцээгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайланд авлага, өр төлбөр буруу дүнгээр тусгагдаж, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн дагуу төсвийг зохистой удирдаж, жилийн эцэст авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, дансны өглөг, авлагын тооцоог бүрэн хянаж байх.

##### **3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

### **3.2. Зардлын данстай холбоотой асуудал**

#### **3.2.1 Илрүүлэлт:**

2019 оны мөнгөн хөрөнгийн журнал, анхан шатны баримтуудыг нягтлан шалгахад харилцах дансны гүйлгээнээс нэр бүхий 3 байгууллагад сурталчилгааны зардалд 7,000.0 мянган төгрөгийг зарцуулсан боловч хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардал дээр данс буруу хуримтлуулж бүртгэсэн.

Таван ажилтанд 2,445.3 мянган төгрөгийн дотоод албан томилолтын урьдчилгаа олгосон боловч томилолтын хуудас болон холбогдох анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээг хүлээн зөвшөөрч зардалд шууд бүртгэсэн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2014 оны 5 тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан " Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар", 2015 оны 7 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан " Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал", 2 дугаар хавсралтаар баталсан " Зардлын эдийн засгийн ангилал", -ын холбогдох заалтуудтай тус тус нийцээгүй ба Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **3.2.2 Эрсдэл:**

Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд зардал, буруу илэрхийлэгдэх, Төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул байх,

#### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2014 оны 5 тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан " Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар", 2015 оны 7 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан " Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал", 2 дугаар хавсралтаар баталсан " Зардлын эдийн засгийн ангилал"-ын холбогдох заалтуудыг тус тус мөрдөж, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

#### **3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>307,280,390.30</u></b>	<b><u>446,535,035.43</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>33</b>	<b>Авллага</b>	-	<b>93,907,519.13</b>
3351	Байгууллагаас авах авлага	-	2,516,519.13
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	91,391,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>307,280,390.30</b>	<b>352,627,516.30</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	219,061,771.00	263,463,897.00
35110	Тусгай зориулалттай материал	218,561,771.00	263,463,897.00
35130	Эм боох материал	500,000.00	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	14,601,103.00	14,601,103.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	72,672,516.30	73,767,516.30
35410	Бичиг хэргийн материал	534,800.00	534,800.00
35420	Аж ахуйн материал	42,457,537.90	43,552,537.90
35430	Сэлбэг хэрэгсэл	3,133,188.40	3,133,188.40
35470	Бусад хангамжийн материал	26,546,990.00	26,546,990.00
35600	Мал амьтад	945,000.00	795,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>8,228,778,591.92</u></b>	<b><u>7,472,635,979.35</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>8,228,778,591.92</b>	<b>7,472,635,979.35</b>
391	Газар	-	-
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>7,949,976,441.90</b>	<b>7,202,906,135.50</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,070,215,210.33	5,695,485,810.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	(56,209,410.00)	(94,924,763.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	111,610,000.00	111,610,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(63,549,111.31)	(77,166,778.03)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,679,672,946.81	3,804,697,066.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	2,514,677,434.39	(2,920,316,703.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	633,908,031.39	663,394,731.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	(382,317,083.58)	(428,380,586.93)
39214	Бусад үндсэн хөрөнгө	334,251,182.55	334,251,182.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	(44,434,786.39)	(68,360,220.39)
39217	Ном	181,506,896.49	182,616,396.49
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>278,802,150.02</b>	<b>269,729,843.85</b>
39301	Програм хангамж	68,019,784.83	68,019,784.83
39302	Хуримтлагдсан элэгдэл	(54,177,634.81)	(63,249,940.98)
39303	Бусад биет бус хөрөнгө /Газар эзэмших эрх /	264,960,000.00	264,960,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>8,536,058,982.22</u></b>	<b><u>7,919,171,014.78</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>9,837,410.70</b>	-
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	9,837,410.70	00.00

<b>413</b>	<b>Өглөг</b>	9,837,410.70	00.00
413103	Татварын өглөг	9,837,410.70	00.00
413102	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/	00.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,526,221,571.52</b>	<b>7,919,171,014.78</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	8,526,221,571.52	7,919,171,014.78
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,939,702,673.59	2,939,702,673.59
51101	Өмч: - төрийн	2,939,702,673.59	2,939,702,673.59
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	131,285,372.76	(475,765,183.98)
51210	Өмнөх үеийн үр дүн	131,285,372.76	131,285,372.76
51220	Тайлант үеийн үр дүн	-	(607,050,556.74)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,455,233,525.17	5,455,233,525.17
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>8,536,058,982.22</b>	<b>7,919,171,014.78</b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,452,939,815.42</b>	<b>3,019,405,245.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>490,393,295.02</b>	<b>583,219,845.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	490,393,295.02	583,219,845.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	490,393,295.02	583,219,845.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	239,476,759.60	336,153,520.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,681,768.42	5,993,786.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	205,234,767.00	167,913,940.00
120009	Бусад орлого	-	73,158,599.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,962,546,520.40</b>	<b>2,436,185,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,906,285,100.00</b>	2,350,641,900.00
